

“ЦАГИЙН ХҮРД” ХӨТӨЛБӨРИЙН ЭХ СУРВАЛЖИЙН
ЖЕНДЭРИЙН БАЙДАЛ

Д.Цэнд*

*СУИС-ийн РТМУС-ийн Сэтгүүл зүйн тэнхимийн ахлах багш, доктор (Ph.D)

Түлхүүр үгс: хүйсийн тэгш эрх, олон нийтийн харилцаа, телевиз, эх сурвалж

2022 оны байдлаар Монгол Улсын хүн ам 3.409.0 мянга үүнээс эрэгтэй 1.674.0, эмэгтэй 1.735.0, (<https://www.1212.mn>, 2022) нийт хүн амын 51 орчим хувь эмэгтэйчүүд байгаа нь хүн ам зүйн хувьд олонх болж байна. Сүүлийн жилүүдэд дэлхий дахинаараа нийгмийн бүхий л давхарга, хүрээнд жендэрийн эрх, тэгш байдалд анхаарлаа хандуулаад байна. Тиймээс ч НҮБ-аас 1975-1985 оныг “Олон улсын эмэгтэйчүүдийн 10 жил” болгон зарласнаас хойш дэлхийн олон улс орон эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах чиглэлд бодлого, хөгжлийн хөтөлбөрүүд гаргаж эхэлсэн. Манай улс “жендэр” хэмээх нэр томъёог 1990-ээд оноос хэрэглэсэн бөгөөд Монгол Улсын Их хурлаас 2011 онд баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль”, Засгийн газрын 2017 оны 129 дүгээр тогтоолоор баталсан “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөр (2017-2021), НҮБ-ын Ерөнхий ассамблейн 2015 оны Эх дэлхийгээ шинэчилье, 2030 он хүртэлх тогтвортой хөгжлийн хөтөлбөр, “Мон-

гол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” зэрэг баримт бичигт хөгжил дэвшилд жендэрийн эрх тэгш оролцоог хангах, аливаа баялгийн үр шимээс адил тэгш хүртэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлэх баримт бичгүүдийг баталж ирсэн. Жендэрийн асуудал нь улс орон бүрийн нийгэм, улс төр, эдийн засгийн хөгжлийн олон талт байдал, нийгмийн тэгш оролцооны асуудал билээ. Тэгвэл олон нийтийн харилцаа, хэвлэл мэдээллийн хэрэгслийн нийтлэл, нэвтрүүлгийн агуулгад хүйсийн тэгш байдлыг хангах нь нийгмийн хөгжилд эрэгтэй, эмэгтэйчүүд тэгш оролцох, хөгжлийн үр шимийг адил тэгш хүртэх боломжийг бүрдүүлэх, нийгмийн нийт гишүүдийн сайн сайхан амьдрах суурь чадавхыг нэмэгдүүлэх үндсэн нөхцөл болох учиртай. Хэвлэл мэдээллээр нийтэлж, нэвтрүүлж буй контентын эх сурвалжийн тэгш оролцоог хангах, төлөвшүүлэн хөгжүүлэх шаардлага бий. Энэхүү өгүүллээр олон нийтийн харилцаа, телевиз, жендэр гэсэн гурван холбоост үйл явцын талаар өгүүлэх ба олон нийтийн мэдээллийн хэрэгслээр дамжуулан хүргэж буй мэдээ, мэдээлэл нь эх сурвалжийн тэгш оролцоог

хангаж чадаж байна уу гэдгийг тодруулах зорилготой.

Монголын үндэсний олон нийтийн телевиз нь олон нийтийн статустай, бие даасан хуультай (МҮОНРТ-ийн тухай хууль /2005/) олон нийтийн эрх ашигт үйлчилдэг, тэдний өмнө хариуцлага хүлээж, хяналт дор нь үйл ажиллагаагаа явуулдаг ашгийн төлөө бус байгууллага юм. МҮОНРТ-ийн тухай хуулийн 8.2.7-д “үндэстний цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхаргын болон олон нийтийн эрэлт хэрэгцээг тэнцвэртэй хангахыг эрмэлзэх” (<https://legalinfo.mn>, 2005) гэж заасан байдаг. Олон нийтийн мэдээллийн хэрэгсэл нь олон нийтийн дуу хоолойг тэгш, хүртээмжтэй түгээх үүргийг хуулиараа хүлээсэн. Тэгвэл энэ үүргээ МҮОНРТ-ийн мэдээллийн Цагийн хүрд” хөтөлбөр хэрхэн биелүүлж, эх сурвалжийн оролцоо буюу хүйсийн тэгш байдал ямар байгаа, мэдээ, мэдээлэл нь эрэгтэй эмэгтэй хүмүүс дуу хоолойгоо илэрхийлэхэд шударга хандаж адил тэнцүү хугацааг олгож буй эсэхийг тодруулах зорилгоор энэхүү судалгааг хийв.

Жендэр хэмээх нэр томъёо нь феминизмийн онолын хөгжлийн явцад бий болсон ойлголт, онол билээ. Жендэр нь нийгмийн харилцааны тухай ойлголт төдийгүй эрэгтэй, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засаг дахь зохион байгуулалтын шинж байдлыг тодорхойлох дүн шинжилгээний хэрэгсэл болж байдаг. Нийгмийн хэрэгцээ өөрөө жендэрийн үүргийг тодруулдаг төдийгүй нийгэм өөрөө жендэрийн ялгаатай байдлыг төрүүлдэг. Нийгэмд жендэрийн үзэл санаа төлөвшихөд олон нийтийн телевизийн үүрэг, нөлөө их бөгөөд энэхүү хэрэгслээр дамжин олон нийтэд хүрч

байгаа мэдээлэл нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн дуу хоолойг адил тэнцүү хүргэх үүрэгтэй.

Нийгэм бол харилцааны үр дүн. Нийгмээс ангид хүн эсвэл адгуус амьтан байхгүй. Хүн бол нийгмийн амьтан “бүтээгдэхүүн” юм. Техник технологийн хөгжил, хотжилтын нөлөө, ахуй, материаллаг байдлын өсөлт, боловсролын хүртээмж, улс төр эрх мэдлийн боломж, эмэгтэйчүүдийн нийгэмд эзлэх байр суурь оролцоо гээд энэ зууны түүхэн өөрчлөлт хувьсал нь олон нийт хэмээх нийтлэг хамтач сэтгэхүйг улам бүр тодруулсан. Ер нь сэтгүүл зүй, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, телевизийн тухай ярихад зайлшгүй харилцаа, олон нийтийн харилцаа хэмээх ойлголтоос эхлэх болдог. Харилцааг хүнтэй, нийгэмтэй холбож ойлгож тодорхойлсноор ерөнхий дүр зураг хийгээд мөн чанарыг нь томъёолох болно. Тэгэхээр телевиз нь хүн хоорондын харилцаанд үйл явдал үзэгдлийн дүр дүрслэлийг хамтдаа суугаад үзэх, сонсох, догдлох боломжийг олгож байдаг хэрэгсэл билээ. “Телевизийн нэвтрүүлэг үзэгчид үзэж байна, эсвэл үзэхгүй байна гэсэн хоёр л шалгууртай” (Өнөрсайхан, 2019) тухай судлаач өгүүлсэн байдаг. Телевиз үзэж байгаа үзэгчид хүрч байгаа мэдээлэл нь агуулгын хувьд иргэдийн дуу хоолой адил тэнцүү илэрхийлэгдэж байх нь чухал юм.

Нийгмийн харилцаа олон янз хэлбэр төрхтэй. Харилцааны онолч “хэн, юуны тухай, ямар хэрэгслээр, хэнд, ямар зорилгоор” (Lassel, 1998) гэсэн загварыг томъёолж авч үзжээ. Мэдээлэгч нь харилцаа ямар өнгө аястайгаар хэрхэн өрнөх, хэнд хүрэх агуулгыг илэрхийлж өгдөг. Судалгааны хүрээнд авч үзвэл сэтгүүлчид мэдээллийн хөтөлбөрөөр ямар хүйс-

ийн хүнээр юуг хэлүүлэх вэ гэдгээ өөрсдөө сонгон түгээх болж байна. Энэ санааг "...телевиз бол харилцааны бүх дүр байдал, тэмдэгтийг агуулж байдаг орчин. Тэгэхээр бид телевизийг жинхэнэ утгаараа хүний харилцааны үргэлжлэлийг тээгч, бас өдөөгч" (Болд-Эрдэнэ, 2017) гэдгээс харж болно. Хэрэгсэл нь харилцааны чухал хүчин зүйл болох нь тодорхой. Олон нийтийн харилцаанд мэдээллийг ямар хэрэгслээр дамжуулсан эсэхээр үр нөлөө, арга хэлбэр, хамрах хүрээ нь тодорхойлогдож байдаг. "Үйл явдал үзэгдлийн яаж болсныг телевиз, юу болсныг радио, яагаад болсныг сонин илүү мэдээлнэ" (Quai, 1987) гэжээ. Телевиз тэр дундаа олон нийтийн хэрэгслээр дамжин хүрч байгаа мэдээлэл нь "олон нийтийн" эрх ашиг, "олон нийтийн" харилцаа байх юм. Монголын үндэсний телевиз нь үүсэн бий болсон цагаасаа 56 жилийн түүхэнд олон нийтийн харилцааны хэрэгсэл байх үүргээ ямар нэг хэмжээгээр биелүүлж ирсэн. Ер нь олон нийтийн телевиз ч байна уу улсын телевиз ч байсан уу хамаагүй түүхэн хөгжлийнхөө явцад харилцааны хэрэгсэл байж ирсэн. Энэ нь өөрөөр хэлбэл хууль эрх зүй, санхүү, бүтэц бүрэлдэхүүний асуудал биш бөгөөд телевиз хэмээх мөн чанарын асуудал юм.

Монгол Улсын "Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль /2011/-д "жендэр" гэж улс төр, эрх зүй, эдийн засаг, нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй хүний гүйцэтгэх үүрэг, хүлээх хариуцлага, тэдний нийгэмд эзлэх байр суурийн талаар уламжлагдан тогтсон, түүхэн явцад хувьсан өөрчлөгддөг ойлголт, үзэл, хандлагыг; "жендэрийн эрх тэгш байдал" гэж эрэгтэй, эмэгтэй хүн улс төр, эрх зүй, эдийн засаг,

нийгэм, соёлын ба гэр бүлийн харилцаанд тэгш эрхтэй оролцож, эдийн засаг, нийгэм, соёлын хөгжлийн үр шимээс тэгш хүртэж, хөгжилд эрх тэгш хувь нэмрээ оруулснаар жендэрийн ялгаварлан гадуурхалтаас ангид байхыг хэлнэ" (<https://legalinfo.mn/>, 2011) гэж заажээ.

Монголчууд эмэгтэйчүүдийн эрх чөлөө, эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн тэгш эрхийн асуудалд язгуураасаа арга, билиг гэсэн үзэл санаанд тулгуурлан ихээхэн хүндэтгэлтэй хандаж ирсэн байдаг. Мэдээллийн хэрэгслүүд ч энэ үзлийг баримталж ирснийг "Ажилчин эмэгтэй" сэтгүүлийн 1931 оны №1 дугаарт Дарьзавын бичсэн "Улсын удирдах хэрэгт ажилчин эмэгтэйчүүд оролцох хэрэгтэй" өгүүллээс харж болно. Тус өгүүлэлд "Засаг захиргааны сонгуульд эмэгтэйчүүдийг өргөнөөр оролцуулах, удирдах ажилтны 20%, захиргааны ажилтны 50%-ийг эмэгтэйчүүдээр сонгох, хоршоо, хамтралын даргаас эхлээд удирдах албанд эмэгтэйчүүдийг дэвшүүлэх" (Ажилчин эмэгтэй) гэсэн байгаа нь жендэрийн үзэл баримтлал, тэгш оролцооны үзэл санааг эмэгтэйчүүдийн сэтгүүл 1930-аад оноос эхлэн дэлгэрүүлж, дэмжин нийтэлж байжээ. Энэхүү үзэл баримтлал нь орчин үеийн жендэрийн тэгш байдлын тухай хуулийн үзэл санаа болж өгсөн байдаг.

Сүүлийн үед хэвлэл мэдээллийн салбарт ажиллаж байгаа бүтээлч ажилтнуудын болон өдөр тутмын сонин, сайтын мэдээний эх сурвалжийн жендэрийн тэгш байдлыг анхааран судалсан судалгаанд "2019 оны байдлаар хэвлэл мэдээллийн салбар дахь бүтээлч ажилтнуудын /сэтгүүлч, найруулагч, редактор/ 62 хувь нь эмэгтэй, радио телевизийн салбарын


удирдах ажилтнуудын 49 хувь, сонин, сэтгүүл, мэдээллийн сайтуудын тал хувь нь эмэгтэйчүүд байгаа бол мэдээний эх сурвалжуудын хувьд өдөр тутмын сонин 14 хувь, мэдээллийн сайтуудын 9.5 хувь нь эмэгтэйчүүд” (<https://www.mediacouncil.mn/>, 2021) байна гэсэн судалгааг хийсэн. Харин арилжааны болон олон нийтийн телевизийн хөтөлбөрүүдийн эх сурвалжийн тэгш байдлыг тухайлан судлаагүй. Иймд МҮОНРТ-ийн мэдээллийн хөтөлбөрөөр үзүүлж байгаа агуулга нь жендэрийн тэгш байдлыг хэрхэн хангаж байгааг тодорхойлох зорилгоор МҮОНРТ-ийн “Монголын мэдээ” сувгийн “Цагийн хүрд” хөтөлбөрийн зургаан сарын 157 дугаарын эх сурвалжид жендэрийн тэгш байдлын тоон судалгааг хийв.

Дэлхий болон Монгол улс жендэрийн тэгш эрхийн асуудалд анхаарлаа хандуулж, нийгмийн оролцооны асуудлыг жигд хан-

гах, нэг хүйс давамгайлсан асуудалд анхаарч үүнээс үүдэн гарах сөрөг үр дагаврыг бууруулах, тэгш байдлыг хангах талаар уриалга, тунхаглал, хууль, баримт бичгүүдийг гаргасаар ирлээ.

Тус хөтөлбөр нь өдөр бүр 20 цагаас 50-60 минутаар дотоод, гадаад, спортын, цаг агаарын мэдээ гэсэн бүтэцтэйгээр долоо хоногийн 6 өдөр олон нийтэд хүрдэг. Ням гарагийн амралтын өдөр “Долоо хоногийн тойм” явдаг. Судалгаанд долоо хоногийн тойм, гадаад болон спортын, цаг агаарын мэдээ ороогүй болно.

МҮОНТ-ийн “Монголын мэдээ” сувгийн “Цагийн хүрд” хөтөлбөрийн 2020 оны 10,11, 12 сар, 2022 оны 10,11,12 сарын 157 дугаар тус бүрийг үзэж эх сурвалжийн хүйсийг тоолон мэдээлэл цуглуулсан. Мэдээллийг SPSS программ ашиглан боловсруулав.



Зураг 1. “Цагийн хүрд” хөтөлбөрийн зургаан сарын дугаарын эх сурвалжийн жендэрийн байдал /2020 оны 10,11,12 сар, 2022 оны 10,11,12 сар/.

Он	Сар	Нийт эх сурвалж	Эмэгтэй эх сурвалж	Хувь
2020 он	10 сар	907	184	20.3
	11 сар	342	99	28.9
	12 сар	659	207	31.4
	3 сарын дундаж үзүүлэлт	1908	490	25.6 %
2022 он	10 сар	779	179	22.9
	11 сар	867	240	27.6
	12 сар	892	318	35.6
	3 сарын дундаж үзүүлэлт	2538	737	29%
Нийт	6 сар	4446	1227	27.5%

Хүснэгт 1. “Цагийн хүрд” хөтөлбөрийн зургаан сарын дугаар дахь эмэгтэй эх сурвалжийн эзлэх хувь.

“Цагийн хүрд” хөтөлбөрийн нэг удаагийн дугаарт дунджаар 15-16 мэдээ, 30-40 эх сурвалжийн яриа багтдаг. 2020 оны мэдээний агуулгын хувьд эрүүл мэндийн буюу цар тахал, вирусийн халдвар, цахим хичээлийн мэдээ зонхилох ба 10-р сард нийт 907 эх сурвалж яриа өгснөөс эмэгтэй 20.3 % (20.3/100) байгаа бол 11-р сард 342 эх сурвалжаас 28.9% (28.9/100), 12-р сард 659 эх сурвалжаас 31.4 % (31.4 %/100) нь эмэгтэй эх сурвалж байгаа нь тоон мэдээллээс харагдана. Судалгааны эхний гурван сар нь Монгол орны хувьд корона вирусийн дотоодын халдвар илэрсэн үе тул хөл хорионы хатуу дэглэм тогтоосонтой холбоотой цөөн эх сурвалж яриа өгсөн байна. Хугацааны сүүлээр эмэгтэй эх сурвалжийн тоо өссөн үзүүлэлттэй харагдаж байгаа боловч энэ үед Эрүүл мэндийн яамны 11 цагийн мэдээг оройн 20 цагийн “Цагийн хүрд”-ээр давтаж үзүүлдэг бөгөөд ХӨСҮТ-ийн хэлтсийн дарга А.Амбасэлмаа, ЭМЯ-ны хэлтсийн дарга Д.Нарангэрэл зэрэг байнга гардаг эмэгтэй эх сурвалжууд эергээр харагдуулахад нөлөөлж байна. Гэхдээ мэдээний агуулгаас харахад эрүүл мэнд, боловсролын мэдээ зонхилж байгаа бөгөөд эрүүл мэндийн салбарт 2020 оны байдлаар 63300 хүн

ажиллаж байгаагийн 82.1 хувь нь эмэгтэйчүүд ((<https://moh.gov.mn/>) , 2020), боловсролын салбарт нийт 99400 хүн ажиллаж байгаагаас 78.1% (78.1/100) ((<https://www.meds.gov.mn/>) , 2020) эмэгтэйчүүд байгаа юм. Энэ нь олон нийтийн телевизийн мэдээллийн хөтөлбөрийн сэдвийн агуулгыг бүрдүүлэгч салбарын ажиллагсдын 50-иас хол илүү хувь нь эмэгтэйчүүд ажиллаж байгаа атал мэдээгээр гарч байгаа эх сурвалжийн 25.6 хувь нь л эмэгтэйчүүд байна.

Тэгвэл судалгаанд хамрагдсан 2022 оны гурван сарыг авч үзье. 10-р сард нийт 779 эх сурвалж яриа өгснөөс 22.9% (22.9% 100), 11-р сард 867 эх сурвалжаас 27.6 (27.6/100), 12-р сард 892 эх сурвалжаас 35.6 (35.6/100) нь эмэгтэй эх сурвалж байна. 2022 он нь 2020 онтой харьцуулахад корона вирусийн тархалт харьцангуй намжсан, хөл хорионы дэглэм цуцлагдаж, улс орон,

иргэд хэвийн амьдралд шилжсэн эх сурвалжаа хайж олоход ямар нэгэн саад бэрхшээл байхгүй болсон үе юм. 2020, 2022 оны тус бүр гурван сараа харьцуулан харвал 2022 онд эмэгтэй эх сурвалж 3.4 хувиар өссөн байна. Өсөлт харагдаж байгаа нь сайшаалтай ч энэ нь төдийлөн тогтвортой өсөлт биш байх

«
2020, 2022 оны тус бүр гурван сараа харьцуулан харвал 2022 онд эмэгтэй эх сурвалж 3.4 хувиар өссөн байна. Өсөлт харагдаж байгаа нь сайшаалтай ч энэ нь төдийлөн тогтвортой өсөлт биш байх магадлалтай юм. Судалгааны зургаан сарын хугацаанд “Монголын мэдээ” сувгийн мэдээллийн хөтөлбөрөөр нийт 4446 эх сурвалж яриа өгсний 1227 нь буюу 27.5 хувь нь эмэгтэй эх сурвалж 70 орчим хувь нь эрэгтэй байгаа нь эх сурвалжийн жендэрийн тэнцвэрт байдал алдагдсан гэдэг дүгнэлтэд хүргэж байна
»

магадлалтай юм. Судалгааны зургаан сарын хугацаанд “Монголын мэдээ” сувгийн мэдээллийн хөтөлбөрөөр нийт 4446 эх сурвалж яриа өгсний 1227 нь буюу 27.5 хувь нь эмэгтэй эх сурвалж 70 орчим хувь нь эрэгтэй байгаа нь эх сурвалжийн жендэрийн тэнцвэрт байдал алдагдсан гэдэг дүгнэлтэд хүргэж байна.

МҮОНТ-ийн мэдээллийн хөтөлбөрийн эх сурвалжийн жендэрийн тэгш байдал алдагдсан үйл явцыг дараах нийгэм эдийн засгийн үйл явц, нөхцөл байдалтай холбон үзэж болох юм. Үүнд: Монгол Улсын хувьд шийдвэр гаргах аль ч түвшинд жендэрийн тэгш байдлыг чухалчлан үздэггүй бөгөөд ямар ч салбарын удирдах албан тушаалд ихэвчлэн эрэгтэйчүүд байдаг. Иймд тухайн асуудлын мэргэжилтний бүлгийн эх сурвалжууд нь ихэнх тохиолдолд эрэгтэйчүүд байх нь түгээмэл. Жендэрийн асуудал, нийгмийн давхаргын талаар сэтгүүлч, сурвалжлагчид ойлголтгүй, төдийлөн анзаардаггүй. Өөрийн бэлтгэн хүргэж байгаа мэдээ, мэдээллийн сэдэв, үйл явдлын цаана байх жендэрийн асуудлыг ухаж гаргаж ирдэггүй бөгөөд энэ талын ойлголт бодлого байхгүйтэй холбоотой. Мөн сэтгүүлч эх сурвалжийн жендэрийн харьцаанд анхаардаггүй нь хамгийн том хүчин зүйл болж байна. Дэлхийн шилдэг мэдээллийн агентлаг болох BBC нь эх сурвалжийн тэнцвэртэй байдлыг хангахын тулд 2016 онд 50:50 төслийг хэрэгжүүлснээр 2022 онд энэ зорилгодоо хүрч эх сурвалжийн харьцаа 50:50 болсон юм.

Хэвлэл мэдээлэл бол олон нийтийн харилцаа олон түмнийг мэдээллээр хангагч хэрэгсэл билээ. Энэхүү хэрэгслээр дамжин олон нийтэд хүрч байгаа мэдээлэл нь

жендэрийн мэдрэмжтэй эрэгтэй, эмэгтэй эх сурвалжийг тэгш хамруулсан байх нь зүйтэй хэдий ч МҮОНРТ-ийн “Цагийн хүрд” мэдээллийн хөтөлбөрийн хувьд энэ харьцаа алдагдаж эрэгтэй эх сурвалж давамгайлж байна.

Монгол оронд ардын хувьсгал ялаад удаагүй, орчин цагийн сэтгүүл зүй үүсэн бий болоод ч олон жилийг ардаа орхиогүй, боловсрол мэдлэг бүхий эмэгтэйчүүд ховор 1930-аад оны үед Монголын хэвлэл эмэгтэйчүүдийг эрчүүдийн нэгэн адил удирдах ажилд сонгуулах, хувь тогтоох тухай хөндөн бичиж байсан нь тэртээх 90 гаруй жилийн өмнө гэхэд томоохон амжилт байлаа. Харин олон арван жилийн хөгжлийн нугачаанд өнөөдөр монголын хэвлэл мэдээлэлд ажиллах ажиллагчдын ч олон нийтийн мэдээллийн хэрэгслээр гарч байгаа мэдээллийн хөтөлбөрийн эх сурвалжийн ч жендэрийн харьцаа алдагдаж эмэгтэй эх сурвалж гуравны нэг хувьтай байгааг цаашид анхаарах хэрэгтэй болж байна.

Эмэгтэйчүүдийн төлөөллийг бүрэн хангахад саад болж байгаа олон хүчин зүйлүүд байдаг хэдий ч сэтгүүлчдийн хувьд таарсан эх сурвалжаас, эсвэл өөрийн хүрээний таньдаг, олдсон нэгнээр эх сурвалжаа хийх биш жендэрийн мэдрэмжтэй эх сурвалжаа сонгох нь зүйтэй байна.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. www.1212.mn
2. www.legalinfo.mn
3. Lasswell H. 1998. The Structure and Function of Communication in Society. NY. 212 pp.
4. Болд-Эрдэнэ Б. 2017. Олон нийтийн харилцаа. х.36.
5. Mc Quai. 1987. Mass Communication Theory. p.78.

6. Өнөрсайхан Т. 2019. Монголын арилжааны телевизүүд: түүх, онол, арга зүй. х.36.
7. <https://www.mediacouncil.mn/>
8. (<https://moh.gov.mn/>)
9. <https://www.meds.gov.mn/>)

Summary

This article discusses the importance of gender equality in public relations and media, arguing that it creates equal opportunities for men and women to participate in social development, enjoy development benefits, and improve their basic life capacity. It examines three

interrelated processes: public relations, television, and gender, with the media's purpose being to clarify gender ratios in 'Wheel of Time, the main political, social, and economic news program of the Mongolian National Broadcaster. The study analyzed the gender ratio of sources in the "Wheel of Time" news program, focusing on October, November, and December 2020 and 2022. Results showed that the gender ratio of information sources in Mongolian Public Television's main news programs has been lost, with male sources dominating.

Keywords: gender equality, public relations, television and sources.